БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2022/100/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Баянхонгор аймаг<br>2022 оны 02 дугаар сар | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 70442584 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mm<br><br>Аудитын менежер: А.Цээням<br>Утас: 99442140 Цахим хаяг: TseenyamA@audit.gov.mm<br><br>Ахлах аудитор: М.Алтантуяа<br>Утас: 99061861 Цахим хаяг Altantuyam@audit.gov.mm<br><br>Аудитор: Л.Доржханд<br>Утас: 99093683 Цахим хаяг: dorjkhandl@audit.gov.mn<br>Цахим хуудас: www.audit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

## Агуулга


1 .Аудитын санал дүгнэлт /Эх хувь/ ............ 2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ............ 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ............ 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ............ 5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ............ 6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ............ 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ............ 8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ............ 10
3. Аудитын тайлан ............ 11
3.1 Ерөнхий зүйл ............ 11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ............ 11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ............ 12
3.4 Материаллаг байдал ............ 12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ............ 12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ............ 13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ............ 14
3.8 Аудитын гол асуудал ............ 14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ............ 14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ............ 15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ............ 15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ............ 15
4. Аудитын илрүүлэлт ............ 16
4.1 Аудитын зөвлөмж ............ 16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ............ 16


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

Аудитын код **БНА-2022/100/НА-СТА-ТШЗ**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.18 № 2/26

танай ____________ -ны № ______________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГА
С.РЭНЦЭНДАГВА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **78,379,334.14** | **83,773,116.14** |
| **33** | **АВЛАГА** | **0.00** | **100,872.00** |
| **335** | **Бусад авлага** | 0.00 | 100,872.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 0.00 | 100,872.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **78,379,334.14** | **83,672,244.14** |
| **354** | **Хангамжийн материал** | **78,379,334.14** | **83,672,244.14** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,149,221.00 | 6,001,951.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 21,752,507.46 | 25,805,507.46 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 3,525.08 | 1,255.08 |
| 35450 | Барилгын засварын материал | 380,000.00 | 380,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 53,094,080.60 | 51,483,530.60 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **461,385,483.23** | **394,388,301.07** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **461,385,483.23** | **394,388,301.07** |
| **392** | **Биет хөрөнгө** | **418,010,483.23** | **351,013,301.07** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 103,822,850.00 | 103,822,850.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -21,280,266.50 | -31,949,550.80 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 108,990,000.00 | 108,990,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -45,428,975.41 | -63,627,124.93 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 248,034,528.14 | 264,027,674.32 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -24,081,975.67 | -72,741,757.98 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 66,817,135.00 | 66,817,135.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -18,862,812.33 | -24,325,924.54 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 3,780,000.00 | 3,780,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -3,780,000.00 | -3,780,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **43,375,000.00** | **43,375,000.00** |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 43,375,000.00 | 43,375,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **539,764,817.37** | **478,161,417.21** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **537,240.00** | **0.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **537,240.00** | **0.00** |
| **413** | **Өглөг** | **537,240.00** | **0.00** |
| **4136** | **Бусад өглөг** | 537,240.00 | 0.00 |
| 41364 | НДШ - ийн өглөг /ТӨҮГ/ | 537,240.00 | 0.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **539,227,577.37** | **478,161,417.21** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **539,227,577.37** | **478,161,417.21** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 268,961,050.75 | 268,961,050.75 |
| 51101 | Өмч: - төрийн | 268,961,050.75 | 268,961,050.75 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **134,815,790.05** | **73,749,629.89** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 134815790,05 | 134,815,790.05 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | -61,066,160.16 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 135,450,736.57 | 135,450,736.57 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **539,764,817.37** | **478,161,417.21** |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,185,381,294.95** | **1,046,513,178.18** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **306,024,494.95** | **41,644,546.18** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **306,024,494.95** | **41,644,546.18** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 306,024,494.95 | 38,050,046.18 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0.00 | 105,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 306,024,494.95 | 37,945,046.18 |
| 120009 | Бусад орлого | 0.00 | 3,594,500.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **879,356,800.00** | **1,004,868,632.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **848,356,800.00** | **996,868,632.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 848,356,800.00 | 996,868,632.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **31,000,000.00** | **8,000,000.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 31,000,000.00 | 8,000,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **902,418,574.66** | **1,107,579,338.34** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **902,418,574.66** | **1,107,579,338.34** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **865,168,128.66** | **1,049,610,618.74** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **598,539,069.00** | **665,942,438.40** |
| 210101 | Үндсэн цалин | 418,752,509.00 | 374,446,255.00 |
| 210102 | Нэмэгдэл | 95,449,551.00 | 142,361,111.60 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 17,697,109.00 | 54,957,804.08 |
| 210104 | Урамшуулал | 66,639,900.00 | 94,177,267.72 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **73,942,228.00** | **86,309,715.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 52,813,373.00 | 60,566,803.86 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,675,842.00 | 6,662,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,926,505.00 | 5,330,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,180,600.00 | 1,332,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,345,908.00 | 12,417,111.14 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **46,366,593.00** | **86,079,007.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,112,799.00 | 5,167,375.00 |
| 210302 | Түлш, халаалт | 38,637,998.00 | 63,696,864.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,615,796.00 | 17,214,768.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **31,919,090.85** | **43,449,680.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 7,075,391.18 | 18,936,810.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,389,574.92 | 5,578,270.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,287,638.00 | 4,142,670.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 267,600.00 | 246,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 440,000.00 | 570,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 13,458,886.75 | 13,975,130.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,619,690.00** | **2,187,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 562,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,619,690.00 | 1,625,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **5,072,500.00** | **4,890,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,072,500.00 | 4,890,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **63,705,640.00** | **56,236,350.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 63,008,240.00 | 54,666,889.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 300,000.00 | 178,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 223,900.00 | 234,952.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 0.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0.00 | 938,809.00 |
| 210807 | Газрын төлбөр | 173,500.00 | 173,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **44,003,317.81** | **104,516,428.34** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,549,766.00 | 21,526,100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 605,000.00 | 0.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 37,848,551.81 | 82,990,328.34 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **37,250,446.00** | **57,968,719.60** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **27,188,761.00** | **53,492,412.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 0.00 | 1,500,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 27,188,761.00 | 51,992,412.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **10,061,685.00** | **4,476,307.60** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,061,685.00 | 4,476,307.60 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **282,962,720.29** | **-61,066,160.16** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | 282,962,720.29 | -61,066,160.16 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | 879,356,800.00 | 1,008,568,132.00 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 0.00 | 3,699,500.00 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 0.00 | 3,699,500.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 0.00 | 105,000.00 |
| 120009 | Бусад орлого | 0.00 | 3,594,500.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 879,356,800.00 | 1,004,868,632.00 |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 848,356,800.00 | 996,868,632.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 848,356,800.00 | 996,868,632.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 31,000,000.00 | 8,000,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 31,000,000.00 | 8,000,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | 868,411,800.00 | 1,008,568,132.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 868,411,800.00 | 1,008,568,132.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 831,161,354.00 | 950,599,412.40 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 598,539,069.00 | 666,023,727.40 |
| 210101 | Үндсэн цалин | 404,296,706.00 | 374,443,255.00 |
| 210102 | Нэмэгдэл | 105,473,561.00 | 142,361,111.72 |

| | | | |
|---|---|---|---|
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 19,279,609.00 | 54,957,804.88 |
| 210104 | Урамшуулал | 69,489,193.00 | 94,261,555.80 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 73,942,228.00 | 86,309,715.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 52,918,100.00 | 60,566,803.86 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,902,800.00 | 6,662,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,058,976.00 | 5,330,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,180,600.00 | 1,332,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,881,752.00 | 12,417,111.14 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 46,366,593.00 | 86,079,007.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,112,799.00 | 5,167,375.00 |
| 210302 | Түлш, халаалт | 38,637,998.00 | 72,796,416.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,615,796.00 | 8,115,216.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 26,678,874.00 | 25,225,669.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,578,920.00 | 6,535,940.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,259,000.00 | 5,672,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,295,638.00 | 4,507,929.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 447,600.00 | 285,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 440,000.00 | 570,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,657,716.00 | 7,654,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,694,690.00 | 3,942,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,975,000.00 | 995,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,719,690.00 | 2,947,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,072,500.00 | 4,890,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,072,500.00 | 4,890,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 68,303,400.00 | 70,353,414.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 67,606,000.00 | 64,723,712.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 300,000.00 | 178,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 0.00 | 234,952.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 223,900.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0.00 | 4,999,050.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7,564,000.00 | 7,775,880.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,351,000.00 | 0.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,213,000.00 | 7,775,880.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 37,250,446.00 | 57,968,719.60 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 27,188,761.00 | 53,492,412.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 0.00 | 1,500,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 27,188,761.00 | 51,992,412.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 10,061,685.00 | 4,476,307.60 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,061,685.00 | 4,476,307.60 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | 10,945,000.00 | 0.00 |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | 10,945,000.00 | 0.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 10,945,000.00 | 0.00 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 10,945,000.00 | 0.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 10,945,000.00 | 0.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | -10,945,000.00 | 0.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 0.00 | 0.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 0.00 | 0.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 268,961,050.75 | 135,450,736.57 | -148,146,930.24 | 0.00 | 256,264,857.08 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 268,961,050.75 | 135,450,736.57 | -148,146,930.24 | 0.00 | 256,264,857.08 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 282,962,720.29 | 0.00 | 282,962,720.29 |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 268,961,050.75 | 135,450,736.57 | 134,815,790.05 | 0.00 | 539,227,577.37 |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 268,961,050.75 | 135,450,736.57 | 134,815,790.05 | 0.00 | 539,227,577.37 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 268,961,050.75 | 135,450,736.57 | 134,815,790.05 | 0.00 | 539,227,577.37 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -61,066,160.16 | 0.00 | -61,066,160.16 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 268,961,050.75 | 135,450,736.57 | 73,749,629.89 | 0.00 | 478,161,417.21 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **0.00** | **0.00** | 0.00 | 0.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **996,868,700.00** | **992,392,324.40** | 4,476,375.60 | 99.55 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **996,868,700.00** | **992,392,324.40** | 4,476,375.60 | 99.55 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **943,356,200.00** | **938,899,912.40** | 4,456,287.60 | 99.53 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **666,289,600.00** | **666,023,727.40** | 265,872.60 | 99.96 |
| 210101 | Үндсэн цалин | 401,055,700.00 | 374,443,255.00 | 26,612,445.00 | 93.36 |
| 210102 | Нэмэгдэл | 107,074,400.00 | 142,361,111.72 | -35,286,711.72 | 132.96 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 63,888,000.00 | 54,957,804.88 | 8,930,195.12 | 86.02 |
| 210104 | Урамшуулал | 94,271,500.00 | 94,261,555.80 | 9,944.20 | 99.99 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **89,896,100.00** | **86,309,715.00** | 3,586,385.00 | 96.01 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 63,244,500.00 | 60,566,803.86 | 2,677,696.14 | 95.77 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,662,900.00 | 6,662,900.00 | 0.00 | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,330,300.00 | 5,330,300.00 | 0.00 | 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,332,600.00 | 1,332,600.00 | 0.00 | 100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,325,800.00 | 12,417,111.14 | 908,688.86 | 93.18 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **86,142,600.00** | **86,079,007.00** | 63,593.00 | 99.93 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,230,700.00 | 5,167,375.00 | 63,325.00 | 98.79 |
| 210302 | Түлш, халаалт | 72,796,500.00 | 72,796,416.00 | 84.00 | 100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,115,400.00 | 8,115,216.00 | 184.00 | 100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **25,315,700.00** | **25,120,669.00** | 195,031.00 | 99.23 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,560,000.00 | 6,535,940.00 | 24,060.00 | 99.63 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,672,000.00 | 5,672,000.00 | 0.00 | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,530,300.00 | 4,507,929.00 | 22,371.00 | 99.51 |
| 210404 | Ном, хэвлэл | 433,400.00 | 285,800.00 | 147,600.00 | 65.94 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 570,000.00 | 570,000.00 | 0.00 | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,550,000.00 | 7,549,000.00 | 1,000.00 | 99.99 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,955,000.00** | **3,942,000.00** | 13,000.00 | 99.67 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,955,000.00 | 995,000.00 | 1,960,000.00 | 33.67 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 2,947,000.00 | -1,947,000.00 | 294.70 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **5,044,000.00** | **4,890,000.00** | 154,000.00 | 96.95 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,044,000.00 | 4,890,000.00 | 154,000.00 | 96.95 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **58,893,200.00** | **58,758,914.00** | 134,286.00 | 99.77 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 53,139,700.00 | 53,129,212.00 | 10,488.00 | 99.98 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 300,000.00 | 178,200.00 | 121,800.00 | 59.40 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 236,000.00 | 234,952.00 | 1,048.00 | 99.56 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 44,000.00 | 0.00 | 100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,000,000.00 | 4,999,050.00 | 950.00 | 99.98 |
| 210807 | Газрын төлбөр | 173,500.00 | 173,500.00 | 0.00 | 100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **7,820,000.00** | **7,775,880.00** | 44,120.00 | 99.44 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,820,000.00 | 7,775,880.00 | 44,120.00 | 99.44 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **53,512,500.00** | **53,492,412.00** | 20,088.00 | 99.96 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **53,512,500.00** | **53,492,412.00** | 20,088.00 | 99.96 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,500,000.00 | 1,500,000.00 | 0.00 | 100.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 52,012,500.00 | 51,992,412.00 | 20,088.00 | 99.96 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **996,868,700.00** | **992,392,324.40** | 4,476,375.60 | 100.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **996,868,700.00** | **992,392,324.40** | 4,476,375.60 | 100.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 996,868,700.00 | 992,392,324.40 | 4,476,375.60 | 100.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **44.00** | **44.00** | 0.00 | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | 0.00 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 40.00 | 40.00 | 0.00 | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 3.00 | 3.00 | 0.00 | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **31,000,000.00** | **8,000,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **31,000,000.00** | **8,000,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **31,000,000.00** | **8,000,000.00** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **31,000,000.00** | **8,000,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 31,000,000.00 | **8,000,000.00** |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 31,000,000.00 | **8,000,000.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 31,000,000.00 | **8,000,000.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 31,000,000.00 | **8,000,000.00** |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Доржханд гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цэсэням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Татварын хэлтэс нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 03 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

Тус байгууллагын дарга С.Рэнцэндагва нэгдүгээр гарын үсэг, нягтлан бодогч Д.Бат-Орших хоёрдугаар гарын үсгийг зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулсан байна.

### 3.2 БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ОРЧИН БА ДОТООД ХЯНАЛТ

Баянхонгор аймгийн Татварын хэлтэс нь улс болон орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх, татварын багц хуулиудын хэрэгжилтийг хангуулах, сургалт сурталчилгаа явуулах үүрэг бүхий Татварын ерөнхий газрын харьяа байгууллага юм. Тайлант онд 44 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийт 996,868.7 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн зорилго зорилт нь: "Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зөв зохион байгуулж, улс, орон нутгийн татварын орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлж, цомхон чадварлаг, үр дүнг эрхэмлэсэн төрийн албыг төлөвшүүлэхэд оршино" гэсэн эрхэм зорилготой.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь Татварын Ерөнхий газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/156 дугаартай тушаалаар батлагдсан Монголын татварын албаны "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Татварын ерөнхий газрын дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 902,418.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 13,536.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 9,475.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 11,629.6 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 61,603.4 мянган төгрөгөөр буюу 11.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь өглөг, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мян.төгр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 78,379.3 | 83,773.1 | 5,393.8 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | 100.9 | 100.9 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 78,379.3 | 83,672.2 | 5,292.9 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 461,385.5 | 394,388.3 | (66,997.2) |
| Үндсэн хөрөнгө | 574,819.5 | 590,812.7 | 15,993.1 |
| Хуримтлагдсан элэгдэл | (113,434.0) | (196,424.4) | (82,990.3) |
| **Нийт хөрөнгө** | 539,764.8 | 478,161.4 | (61,603.4) |
| Өр төлбөр | 537.2 | - | (537.2) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 539,227.6 | 478,161.4 | (61,066.2) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 539,764.8 | 478,161.4 | (61,603.4) |

Эх сурвалж: Санхүүгийн тайлан 2021 он

Бараа материалын дансны үлдэгдэл 83,672.2 мянган төгрөг болж 5,292.9 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 2,852.8 мянга, аж ахуйн материал 4,053.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба Татварын ерөнхий газраас үнэ төлбөргүй нийлүүлсэн бараа материал голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 590,812.6 мянган төгрөг болж 15,993.1 мянган төгрөгөөр өссөн ТЕГ-аас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан тоног төхөөрөмжийн орлогыг бүртгэсэнтэй холбоотой байна. Мөн тайлант онд үндсэн хөрөнгийн зарлагын гүйлгээг хийгдээгүй байна.

Өмнөх онд үүссэн нийгмийн даатгалын шимтгэлийн өр 537,2 мянган төгрөгийг тайлант онд 100 хувь барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 478,161.4 мянган төгрөг болж 61,603.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 61,603.4 мянган төгрөгийн өөрчлөлтөөс буюу үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,169,990.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,169,990.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 170,122.2 мянган төгрөгөөр бууруулж 996,868.7 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотгол хийгдээгүй байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 996,868.7 мянган төгрөгийн төсөв батлснаас 996,868.7 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 996,868.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 992,392.3 мянган төгрөгийг зарцуулж 4,476.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Засаг даргын үндсэн чиглэлийн биелэлтийг хангуулах зорилгоор тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 8,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд орлогыг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 73 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 100 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Тус байгууллага нь ТӨБЗГ-ын 2021.11.15-ны өдрийн А-1/1877 дугаартай албан бичгээр шилжүүлэн бүртгэх зөвшөөрөл олгосны дагуу 15,993.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг ТЕГ-аас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна..

**3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 1,107,579.3 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 205,160.8 мянган төгрөгөөр буюу 22.7 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, эд хогшил, урсгал засварын зардал байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд нь өмнөх оноос нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Тайлант онд байгууллагын ахмадын сангийн дансанд үндсэн данснаасаа 3,594.5 мянган төгрөг төвлөрүүлж байгууллагын 13 ахмадууддаа 3594,5 мянган төгрөгийн хүндэтгэл үзүүлсэн байна.

**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 996,868.6 мянган төгрөгийн 151 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 996,868.6 мянган төгрөгийн 149 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээлэл хугацаа болоогүй байна.

*Хүснэгт 2.* Шилэн дансны мэдээлэл

| д/д | Хугацаа | Төрөл | Мэдээлвэл зохих/удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 9 | 0 | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | 0 | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | 0 | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 36 | 0 | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 96 | 0 | |
| | Нийт | 27 | 151 | 149 | 0 | 2 |

Эх сурвалж: шилэн дансны нэгдсэн системээс

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

Тайлант онд 996,868.7 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж гүйцэтгэлээр 992,392.3 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 4,476.4 мянган төгрөг буюу төсвийн 0.4 хувийг буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж 2021.05.03-ны өдрийн 147 дугаартай албан бичгээр хэрэгжилтийг хүргүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар зөрчил давтан гаргахгүй байх 17,164.9 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг хүргүүлэв.

### 4.1 Аудитын зөвлөмж

1. <u>Илрүүлэлт</u>

Тус байгууллагын 2021.12.13-ны өдрийн А/71 дүгээр тушаалаар томилогдсон комисс тооллого хийж, нягтлан бодогч тооцоог бодсон боловч үр дүнг хэлэлцэж тушаалаар баталгаажуулаагүй байна.

Энэ “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 72 дугаар зүйл “Тооллогын комисс, түүний эрх,үүрэг”, 72.4.4 дэх заалт “Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

*<u>Эрсдэл:</u>* Тооллогын дүнг баталгаажуулаагүй байх, батлагдсан төсвийг хэмнэж ажиллах

*<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Тооллогын комисс тооллогын үр дүнг хэлэлцэж тушаалаар баталгаажуулан холбогдох акт материалын хамт ерөнхий нягтлан бодогч болон өмч хамгаалах байнгын зөвлөлд хүргүүлж байх.

2. <u>Илрүүлэлт</u>

2. Тус байгууллагын 2021 оны байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 86,142.6 мянган төгрөгөөр батлагдаж 86,079,0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд нийт 17,164.9 мянган төгрөгийг хэмнээгүй байгаа нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.8 дахь заалтыг зөрчсөн байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мян.төгрөгөөр/

| № | Төсвийн захирагчийн ангилал | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | ТШЗ | 1 | | | | | | | | 1 | |
| | Дүн | 1 | | | | | | | | 1 | |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | ТШЗ | 1 | 17,164.9 | | | | | | | 1 | 17,164.9 |
| | Дүн | 1 | 17,164.9 | | | | | | | 1 | 17,164.9 |
| | **НИЙТ ДҮН** | 2 | 17,164.9 | | | | | | | 2 | 17,164.9 |